

ӨМНӨД АЗИ ДАХЬ ГЕОПОЛИТИКИЙН ШИНЭ ХУВЬСАЛ

МУИС, ОУХС-ийн
ахлах багш Д.Баярхүү

1. Хуучнаар Дундад Ази буюу одоогийн Төв Ази, цаашлаад Каспийн сав газрыг оруулаад *"Их Дундад Ази"* хэмээн эртний ба дундад зууны үеийн Хятадын эх сурвалжид оноож нэрлэсэн байдаг. Тухайн цагтаа хятадууд чухам ямар хэмжүүр шалгуураар тэгж нэрийдсэн нь бүү мэд, ямартай ч *"Торгоны их зам"* үүгээр дайран өнгөрч, Шинжаан хүрч тэндээсээ Хятадын төв рүү хүрдэг байжээ.

Бүр сүүлд ХХ зууны 2 дугаар хагаст Азийг Европоос газар зүйн хувьд ялгах, Азийн баруун хэсэг, Европын дорнод хэсгийг зааглахдаа НҮБ-ын баримт бичгүүдэд хятадуудын уламжлалт газар зүйн заагаар тогтоосон нь бодит хуваалт гэж нийтээрээ үзсэн учир шалтгаанаас үүдэлтэй.

Геополитик талаас нь авч үзвэл, 1904 онд Британийн геополитикч Х.Маккиндер *"Өвөр Еврази"* гэсэн нэр томъёо гаргаж, Ижил мөрнөөс Лена мөрөн хүртэл өргөнтэй, уртаашаа Хойд мөсөн далайгаас Персийн булан гэж авч үзэн, *"Тэнхлэгийн бүс"* хэмээн нэрлээд, хожим нь 1919 онд 1 дүгээр дайны дараа *"Хартлэнд"* буюу махчлан орчуулбаас "дэлхийн зүрх" хэмээжээ. Маккиндертэй зэрэгцээ шахуу Оросын нэгэн сэтгэгч А.Е.Снесарев гэгч Төв Азид: *Туркестан, Шинжаан, Энэтхэг, Афганистан, Иран, Түвдийг* оруулж тооцоод *"дэлхийн бодлогын түлхүүр"* гэж томъёолсон байх аж. Түлхүүр гэдэг нь тэр үедээ Британийн цайзад хүрэх гарцыг нэрлэсэн хэрэг. Үнэндээ ч дайны дараа Британи хүчээ бараад, бас ч нөгөө талаар Оттоманы эзэнт гүрнээс салгаж авсан нефтийн орд руугаа орж эхэлсэн, Их Оросын, Хятадын сонирхол тэнд мөн нэгэн зэрэг өсч байсныг тэгж бодолцсон байх. Хоёрдугаар дайнаас хойш тэндхийг "Турав дахь ертөнцийн эпицентр" гэж үзсэн явдал Энэтхэгээр жишээлэн гарчээ.

2. Үндэсний аюулгүй байдал, цэргийн номлол, эсвэл аюулгүй байдалд заналхийлэх хүчин зүйлс, түүний эсрэг авах арга хэмжээ зэрэг ойлголтууд юуны түрүүн газар зүйн буюу геополитикийн хүчин зүйлээс хамаардаг зүй тогтолтой. *"Геополитикийн орчин"* гэдэг ухагдахуунаар тодорхой улс орныг авч яривал, тэр нь тухайн бүс нутгийнхаа хямралын тэнхлэг, голдрилд багтаж буй эсэх, хэрэв багтаж буй бол хэвтээ босоо аль тэнхлэгт, хямралаас хол оршдог байлаа гэхэд нийт цагригийн аль тойрогт орох эсэхийг тодруулах шаардлагатай. Аливаа дайн мөргөлдөөний үүх түүхийг сөхөж үзвээс тухайн үеийн дэлхийн гол гүрнүүдийн хооронд орон зайн төлөөх тэмцлийн хэлбэрээр бараг бүгд илэрсэн байдаг. Орон зай гэдэг нь соёл иргэншил, шашин, улс төр-эдийн засгийн нөлөөгөө тэлэхээр товлосон бүс нутгуудыг нь хэлж буй хэрэг. Дэлхийн 2-р дайн нь хэвтээ тэнхлэгийн хямрал байсан бол 2-р дайнаас хойшхи ихэнх мөргөлдөөнүүд

ОУХС-ийн Д.Баярхүү

цаашлаад
ба дундад
хайн цагтаа
нь бүү мэд,
жаан хүрч

газар зүйн
зааглахдаа
ийн заагаар
налтгаанаас

еополитикч
л мөрнөөс
с Персийн
1919 онд 1
хийн зүрх"
сэтгэгч
аганистан,
хүүр" гэж
айзад хүрэх
бараад, бас
рд руугаа
зэрэг өсч
ийг "Гурав
гарчээ.

аюулгүй
жээ зэрэг
н зүйлээс
дахуунаар
ямралын
босоо аль
тойрогт
өний үүх
ронд орон
Орон зай
тэлэхээр
нь хэвтээ
мдоонүүд

босоо тэнхлэгт явагджээ. Яг одоо Афганистанд болж буй учир битүүлэг дайныг босоо тэнхлэгт оруулж болно. Энд хөгжиж буй ядуу "өмнийхний" баян "умаршаа" хийхээр зэхэж буй "их нүүдлийг" таслан зогсоох дайн явагдаж байгаа нь энэ. Цаашлаад Евразийн цээжин дэх дэлхийн баялгийг дахин хуваах, тэндхийн орон зайг эзэгнэхийн төлөө их гүрнүүдийн тэмцэл залгана гэсэн үг.

Улс орнууд цэргийн номлолоо боловсруулахдаа, учирч болох аюул заналыг тодорхойлдог. Цэрэг, зэвсгийн хүчийг хэзээ, ямар тохиолдолд хэрэглэх тухай урьдчилсан дүгнэлт гэсэн үг юм. "Хүйтэн дайны" үед социализм капитализм хоёр босоо тэнхлэг дээр сөргөлдөж байх үед Москвагаас АНУ-д, Вашингтоноос Зөвлөлтөд, Европын орон зай дээр НАТО-Варшавын гэрээний хооронд харилцан учрах аюул заналын тухай тооцдог байсан бол эдүгээ "Өмнөөс" "Умардад" учрах уламжлалт бус аюулын тухай тооцох болов (яг үнэндээ бол АНУ-д учрах бодит аюул үгүй мэт байсан боловч тийм аюулын тоонд одоо Талибаны дэглэмийн ивээл доорхи олон улсын лалын терроризм, наркотрафик орж байна). АНУ-ын зэвсэгт хүчин Дундад Дорнод, Солонгосын хойгт нэгэн зэрэг дайн хийвэл хоёуланд нь ялахуйц чадавхитай байхаар цэргийн номлолоо шинээр боловсруулжээ. Сүүлийн 10 жил Персийн буланд байнга жижүүрлээстэй Иракийг дарамталж ирсэн нь цаанаа учир шалтгаантай. Нэгэнт бэлдчихсэн байсан тул Афганы эсрэг тусгайлсан бэлтгэл хийгээгүй.

Хэвтээ тэнхлэг гэж ярьсных, Евразийн орон зай дээрх өнөөгийн хямралыг дэлгэрүүлж тайлбарлая Баруун буюу Бага Ази-Төв Ази-Өмнөд Азийн гурвалжингийн хоорон дахь зурваст өрнөж буй өнөөгийн мөргөлдөөн нь загалмайтны шашинт "Баруун", түүний ясны эсэргүүцэгч "Лалын" ертөнцийн тэмцлийн орон зайд тохиож байна. Энэ тэнхлэгийг нэгтгэн цагриван тойрог болговол, Евразид: 1. Хямралын голомт буюу цэрэглэсэн интервэнцэд ертөмхий район нь өнөөдөр Афганистан болж байна. 2. Хоёрдугаар тойрогт хойшоо шинэ Дундад Ази, барууншаа Каспи ба Кавказ, өмнөшөө Кашмир, Каргил, зүүншээ Шинжааныг оруулж тооцох бөгөөд 3. Гадуурхи тойрогт хойшоо Умард Кавказ-Каспи-Ижил-Урал, барууншаа Бага Ази-Ойрхи Дорнод, өмнөшөө Энэтхэг, зүүншээ Өвөр Ази гэсэн тэнхлэг үүсч болох юм.

3. "2001.09.11"-ний үйл явдлаас хойш *Төв Ази – Каспи – Кавказын тэнхлэгийн* бүс нутаг дэлхийн улс төр, цэрэг, дипломат, мөн бизнесийн хүрээнийхний анхаарлыг гойд ихээр татах болов. Магадгүй түүхэндээ энэ бүс нутаг хамгийн ихээр анхаарагдаж байгаа нь энэ байх. Үүний өнгөн талын учир шалтгаан бол мэдээж, олон улсын алан хядагчдын гол баазыг олж устгах, тэднийг орогнуулж өөгшүүлснийх нь төлөө Талибаны хараал идсэн дэглэмийг цээрлүүлэх явдал. Яг нарийн дээрээ бол гол шалтгаан нь Каспийн тэнгисийн нефть, байгалийн хийн нөөц баялаг ажгуу. ОХУ, АНУ, Хятадтай өрсөлдөх хэмжээнд очтолоо Энэтхэг, Норвегээс эхлээд Японыг хүртэл "капиталист" гэгдэх том жижиг бүх улс энэ их нөөцийг сонирхон харж байна. Өрнөдийн (АНУ голлон тоглогч нь) нефтийн компаниудын сонирхлоос үүдэн Кавказ, Төв Азийн олон улсын ач холбогдол ийнхүү өсөн нэмэгдсээр л. Гэхдээ нефть нь цорын ганц хүчин

зүйл гэвэл бас биш юм. Эх газарт түгжигдсэн Каспийг тэнгис гэх үү, нуур гэх үү гэдэг нь ч маргаантай. Оросын хувьд олон улсын тэнгис гэхээсээ нуур гэж тодорхойлох нь байдаг.

Хуучин СССР-ийн үед өмнөд бүс нутагт эдийн засгийн болон улс төрийн нөлөөгөө тогтоохын төлөө тэмцэл бүр 1991 оноос эхэлжээ. Нэг талаас Орос улс хуучин эзэнт гүрнийхээ бүрэлдэхүүн хэсэгт ноёрхлоо сэргээн тогтоохыг эрмэлзсээр өнөө хүрсэн бол нөгөө талаас Турк, Иран зэрэг бүс нутгийн "шинэхэн гүрнүүд" өөр өөрсдийн нөлөөний хүрээгээ өргөжүүлэхийн төлөө эл өрсөлдөөнд зөнгөөрөө татагдан оржээ.

Газар зүйн талаас нь авч үзвээс Орос, Хятад, Афганистан, Иран гэсэн 4 улс л Төв Азитай ("4+5" гэсэн томъёоллоор авч үзье) хиллэдэг. Төв Ази нь Пакистан, Энэтхэгээс хэдхэн километрээр зааглагдаж буй. Өөрөөр хэлбэл Төв Ази хэмээх бүс нутаг нь XXI зуунд "бүс нутгийн их гүрнүүд" болж болзошгүй, яг тийм амбицтай хэсэг улсаар ("4+5+2") хүрээлэгдэж байна. Эдгээрийн 4 нь цөмийн зэвсэгтэй. Бүс нутгийг хүрээлэгч улсуудын олонхи нь барууны, ялангуяа Америкийн нөлөөг төдийлөн таашаадаггүй улсууд юм.

Эдүгээ Афганд явагдаж буй "гадныхны халдлагыг" ярихдаа энэхүү эмгэнэлтэй ард түмэн хийгээд тэдний урагшгүй удирдагчдын тухай бус, эсвэл "терроризм" гэгч нэр хаяггүй нэгэн "дайсны" тухай бус, харин тийм халдлагыг нөхцүүлэгч геополитикийн орчны тухай яривал илүүтэй үнэнд ойртох биз ээ.

4. Ирэх 25 жилд Хятад, Энэтхэг зэрэг дэлхийн томхон орнууд эрчим хүчний хомсдолд орж, хүндхэн асуудалтай дараалан тул арах тухай эдүгээ янз бүрийн прогноз бий. Өдөр ирэх тусам өсөн нэмэгдэж буй нефтийн үнэ төлөх боломжгүй болж буй Хятад улс тэр үед *Ойрхи Дорнод, Каспи, Сахалины баялгийг шударгаар хуваах, шударга үнээр хамтран эзэмших* шаардлага тавьж болзошгүй. Ийм тохиолдолд Өмнөд Хятадын тэнгист цэргийн хүч үзүүлж Япон, Солонгос руу яваа нефтийн танкеруудын замыг хаах, татвар төлөхийг шаардах вий. Энэтхэгийн далай болон Бенгалын буланд Энэтхэг мөн ийм манераар ажиллах асуудал ч үндэслэлгүй биш юм. Өнөөдөр цэргийн хүчээ бэхжүүлж, Оросоос стратегийн зориулалттай зэвсэг авч буй энэ улс нисэх онгоц тээгч хүчирхэг хөлгөөр Персийн буланг хааж нефтийн тээвэрлэлтийг тасалдуулахыг ч үгүйсгэхгүй. Энэ бол цэрэг-стратегийн прогнозчдын дэвшүүлдэг нэг хувилбар нь.

Оросыг (Сахалин) эс тоовол Ази, Номхон далайн бүсийн орнууд эрчим хүчний нөөцөө аль хэдийнээ шавхаж дуусч байна. *Модоо баригчдын жагсаалтад* баян тансаг Хятад нэмэгдэн орж ирлээ. Нэгэн цагт нефть шатдаг хийгээр гайхуулж явсан Индонез одоо импортлогчдын эгнээнд орлоо. Брунейн их нефть, хий нь гадагшаа бүс нутгийн эрчим хүчний хомсдолд юу ч болохгүй. Нефтийн асар том хэрэглэгч Энэтхэгт ийм гачлан нэгэн адил тулгарвал хэрхэх вэ? Өнөөдөртөө Аравын тэнгисийн районд нефть олборлодог нь тус орны асар их хэрэгцээг дөнгөн данган хангах ба эрчим хүчний гол түүхий эд- шатдаг хийн асуудлаар Ираныг

түншлэлдээ татан оруулж эхэлсэн нь хэтийн төлөв ирээдүйгээ урьдчилан тооцсон хэрэг болох биз ээ.

Энэчлэн энд тэндгүй хомсдол үүсч эрчим хүчний хямрал дэгдсэнээс үүдэн *Дундад Дорнод- Каспийн нефть, байгалийн хийн төлөө* урьд өмнө үзэгдээгүйгээр ширүүн өрсөлдөхөд хүргэж болзошгүй (Миний энд бичиж буй таавар таамаг манай эх орныг дайрахгүй өнгөрнө гэж бид бүү хууртъя). Евразийн орон зайн энэхүү өрсөлдөөнд хамгийн их нөлөөлөх нь *"Их Хятадын геополитик"* байх бөгөөд АНУ болон барууныхны бодлоготой тулгарах солбицохын хослуулах тухайд ч одоо их бичих болжээ. Хятадын зүгээс эрчим хүчний шаардлага өсч Персийн булан-Каспийг сонирхож эхэлсэн нь Америкийн үндэсний ашиг сонирхолтой хослож, үүний үр дүнд нефть олборлолтын өргөн бүсэд чөлөөтэй нэвтрэх бололцоог Бээжингийнхэнд олгож болох юм. Ингэснээр тэндхийн улс төрийн нэн тогтвортой байдлыг АНУ, Хятадын аль алин нь сонирхох болно.

5. Каспийн нефть хийн бүс руу аажмаар нэвтэрч буй Энэтхэг энэ их өрсөлдөөнд Орос, Ираныг түшихийг илүүтэй зорьж буй нь АНУ-ын байр суурьтай зөрчилдөж байна. АНУ нь Орос-Ираны холбоог эндээс шахан гаргаж, харин баруун өмнөд чиглэлд *Өвөр Кавказ-Турк-Газар дундын тэнгисийн тэнхлэг*, дараагийн хувилбараар зүүн өмнөд чиглэлд *Афганистан-Пакистан-Энэтхэгийн далайн тэнхлэг* гэсэн 2 үндсэн чиглэлийг сонгон авчээ. АНУ-ын 2 дахь сонголтод Энэтхэг болон бүхэлдээ Өмнөд Азийн геополитикийн орчин хамааралтай. Энд цөмийн зэвсэг бүхий Энэтхэг, Пакистан хоёрыг АНУ-ын холбоотон буюу стратегийн түншийн хэмжээнд авч үзэн, харилцаагаа аль болох зөөлрүүлэх, улмаар тэр 2 орны түүхэн зөрчлийг намжааж, Кашмирын асуудлыг олон улсын хэмжээнд бүрэн зохицуулах шаардлага тулгарч байна. Энэ үүднээс Дели-Исламабад руу АНУ-ын дипломат бодлого чиглэсээр 3 жилдээ орж байна. АНУ-ын Ерөнхийлөгч 2000 оны 3 дугаар сард тус 2 оронд зэрэг айлчилж, БНЭУ-ын Ерөнхий сайд мөн оны намар Вашингтонд очсоноор АНУ-Энэтхэгийн хооронд жинхэнэ холбоотны харилцаа төлөвшиж эхэлсэн болно.

6. Афганистаны шинэ дайн эхэлж байхтай давхцан БНЭУ-ын Ерөнхий сайд ОХУ-д айлчилсан ба айлчлалын дараа Өмнөд Ази-Төв Азийг холбосон тэнхлэгт Энэтхэгийн хатуу оролцоо бүхий геополитикийн шинэ хувиралт гарч эхлэв. Энэ нь Афганистаны ирээдүйн засгийн газрыг эмхлэн байгуулах асуудлаар Оросын талаас дэмжлэг хүлээсэн, мөн НҮБ-д дэмжигдэж буй Энэтхэгийн саналтай шууд холбоотой. Төв Азийн халуун цэг болж буй энэ оронд "Олон угсаатны өргөн хүрээтэй засгийн газар" байгуулахыг Орос, Энэтхэг хоёр санал болгосон, хариуд нь өрнөдийнхөн "6+2" хувилбараар эсрэг санал дэвшүүлсэн. "6" гэдэг нь Афгантай хил залгаа Узбекистан, Тажикистан, Туркменистан, Иран, Пакистан, Хятад зургаа ба дээр нь ОХУ, АНУ хоёр зайлшгүй орох тухай хувилбар юм. Энэ эгзэгтэй саналыг сэргүүлж Энэтхэгийн Ерөнхий сайд Москвад очоод байхдаа "7+2" хувилбарыг дэвшүүлж 7 дахь оролцогч зайлшгүй Энэтхэг

байх тухайд Оросын Ерөнхийлөгч тэр даруйд нь дэмжжээ. Энэ саналаа дэмжүүлэхээр Энэтхэгийн тал одоо олон талт дипломат бодлогоо эрчимтэй явуулж байна. АНУ, түүний холбоотнууд НҮБ-тай хамтран Афганистаны ирээдүйн засгийн газрын тухай асуудал хэлэлцэх улсын тоог 20-д хүргээд буй нь БНЭУ-ын дипломат бодлогын үр дүн байлаа. Энэ 20 улсад: аж үйлдвэржсэн 8, Төв Азийн 5, Пакистан, Энэтхэг, Иран, Хятад, Турк, Египет, Швед орж байна. Ийнхүү Афганы асуудлаархи "20-ийн бүлгийн" механизм төлөвшив.

Article is about geopolitical changes that the South Asia is undergoing at the moment. Author studied it from angle of six aspects, in particular, from point of crossing interests of the sub - region i.e. India, China, Russia and USA. Author linked further the issue with the recent Caspian sea oil and gas exploration and positions of the Central Asian and South Asian countries.